



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан



Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, олон нийтэд мэдээлэх ажил хууль журмын дагуу зохион байгуулагдсан боловч зарим сум үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ боловсруулж, батлуулаагүй байна

2017 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Д.Оюунбат 2017 оны 12 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Нутгийн удирдлагын ордон, 2 давхар, 209 тоот	Товчилсон үгийн тайлбар..... Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй..... Бүлэг 1: Зарим сум 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ боловсруулж, батлуулаагүй байна. 1.1. Зарим сум 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ боловсруулж, батлуулаагүй байна. 1.2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийн, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулсан байна. 1.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөлийн урьдчилсан үнэлгээ хийгээгүй, олон нийтээр хэлэлцүүлээгүй бөгөөд зарим сумд үйл ажиллагааны хөтөлбөрөө хуульд заасны дагуу төлөвлөөгүй байна. 1.4. Зарим сум үндсэн чиглэлээ боловсруулж батлуулаагүй байж, төсөв авч зарцуулсан байна. 1.5. Сумдын Засаг дарга нар Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг ИТХ-д өргөн мэдүүлэхдээ хуулийн хугацаа хоцроосон байна. 1.6. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах, чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан байна. Бүлэг 2: Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. 2.1. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлагнасан байна. 2.2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулсан байна. 2.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэнд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна. Бүлэг 3: Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.
--	---

3.1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх сурталчлах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

3.2. Зарим сумын Засаг дарга хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Дүгнэлт:.....33

Зөвлөмж:.....34

Холбогдох байгууллагын санал.....35-41

Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар....42-43

Хавсралтууд.....

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Үндэсний аудитын газраас баталсан аудитын төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт:

Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, Засаг даргын тамгын газрыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, харьцуулан шинжлэх, түүвэрчлэн шалгах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх, санал асуулга авах зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

3. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Д.Оюунбат гүйцэтгэв.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Аудитын явцад 2017 оны ажлын хэсгийн баримт материалыг үдэж цэгцлээгүй, сумдын ажил хариуцсан ажилтнууд солигдсон зэрэг нь аудитын хугацаа алдах буюу үйл ажиллагааг дүгнэхэд хүндрэлтэй байлаа.

Бүлэг 1

Зарим сум 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ боловсруулж, батлуулаагүй байна.

1.1 Зарим сум 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ боловсруулж, батлуулаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 17-д заасны дагуу аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2016 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн А/239 тоот захирамжаар 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогч ахалж, гишүүдэд ЗДТГ-ын дарга, ТЗУХ-ийн дарга, ХЗХ-ийн дарга, СТС-ийн хэлтсийн дарга, НХХ-ийн дарга, ХБХ-ийн дарга, ХШҮТ-ийн дарга, Хөгжлийн бодлогын хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, “Онош” ТББ-ийн тэргүүн зэрэг албан тушаалтнуудыг оролцуулсан байна.

Төсөл боловсруулах ажлын хэсэг нь 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдөр аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулах ажлын төлөвлөгөө гарган ажлын хэсгийн ахлагчаар батлуулсан байна.

Тус төлөвлөгөөнд 8 төрлийн ажил хийгдэхээр заагдсан бөгөөд аймгийн хөгжлийн цогц бодлогод үндэслэн суурь бодлогыг тодорхойлох, нөхцөл байдлын шинжилгээ хийх, нээлттэй хэлэлцүүлгээс 7 хоногийн өмнө мэдээллийн хэрэгслэлүүдийг ашиглан төслийг олон нийтэд хүргүүлсэн байх зэрэг журамд заагдсан үзүүлэлтүүд тусгагдсан байна.

Мөн аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/294 тоот захирамжаар дэд хөтөлбөрүүдийг шинэчлэн батлуулах ажлын хэсэг байгуулж, хөтөлбөр тус бүрт салбар ажлын хэсгийг байгуулсан байна.

Ажлын хэсгүүд төлөвлөгөөний дагуу ажлын тайланг нэгтгэн төсөл, бодлогын хувилбаруудын төслийг эцэслэн боловсруулж, холбогдох хавсралтын хамт аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

Сумдууд аймгийн Хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэн өөрсдийн онцлогийг тусгасан үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулахдаа аймгийн 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс сумдад хамааралтай асуудлыг авч тусгасан төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын Засаг дарга нар Хөгжлийн бодлогын баримт бичгээ дараах хугацаанд батлуулсан байна. Үүнд:

№	Хөгжлийн бодлогын баримт бичгийг батлуулсан байдал			Баталсан байгууллагын нэр
	Нэр	Огноо	Шийдвэрийн дугаар	
1	“Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”	2016.11.30	04	Аймгийн ИТХ
2	Дэд хөтөлбөрүүдийн жагсаалт /10 хөтөлбөр/	2016.12.02	27, 67-75	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид
3	Баянтал сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”	2016.12.18	08	Баянтал сумын ИТХ
4	Сүмбэр сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”	2016.12.15	06	Сүмбэр сумын ИТХ

Хүснэгтээс харахад: аймгийн Засаг дарга болон Баянтал, Сүмбэр сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 онд хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ хуулийн хугацаанд боловсруулж батлуулсан байхад Шивээговь сумын Засаг дарга 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ боловсруулж, батлуулаагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна” гэснийг зөрчсөн байна.

1.2 Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийн, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулсан байна.

“Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 9-т заасны дагуу аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 10 дэд хөтөлбөрийн хамт Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого 2010-2021, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, олон нийтийн саналд үндэслэн боловсруулсан байна.

Нөхцөл байдлын дүн шинжилгээг хийхдээ Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлын талаар нэгдсэн судалгаа гаргасан ба үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөрүүд салбар тус бүрээр нөхцөл байдлын шинжилгээ хийсэн байна.

Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр өрсөлдөх чадварын индексээр аймгуудаас 7 дугаар байранд, дэд бүтэц, засаглалын үр ашиг, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хүн амын амьжиргааны түвшин зэрэг үзүүлэлтээр аймгуудын дунджаас өндөр боловч эдийн засаг, бизнесийн үр ашгийн үзүүлэлтээр аймгуудын дунджаас доогуур гэж үнэлэгдсэн байна.

Иймд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад нэн тэргүүнд бизнесийн орчин буюу хувийн хэвшлийн чадамжийг

сайжруулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодлогын хувилбаруудыг чиглүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 5 бүлэг болгон бүлэг бүрт 1 зорилго тавьсан ба зорилгуудыг хэрэгжүүлэх 32 хувилбар боловсруулж, хувилбаруудыг хэрэгжүүлэх нийт 119 арга хэмжээг төлөвлөсөн байна. Аймгийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулахдаа аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт заагдсан арга хэмжээг бүрэн тусган хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Аймаг хөгжүүлэх хэтийн зорилт болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго зорилтыг тодорхойлохдоо Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах нийтлэг журмын арван нэгдүгээр бүлгийн 55.2, 55.6, 55.7-д заасан дагуу Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудад үндэслэн боловсруулсан бөгөөд журмын 55-д заасан зорилго, зорилтын уялдааг хангаж боловсруулсан байна.

Сумдууд аймгийн хөгжлийн цогц бодлого, Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн бодлогын баримт бичгээ боловсруулсан бөгөөд аймгийн үйл ажиллагааны хөтөлбөрөөс сумдад хамааралтай арга хэмжээг бүрэн авч тусгасан байна.

1.3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөлийн урьдчилсан үнэлгээ хийгээгүй, олон нийтээр хэлэлцүүлээгүй бөгөөд зарим сумд үйл ажиллагааны хөтөлбөрөө хуульд заасны дагуу төлөвлөөгүй байна.

Аймаг болон Сүмбэр сум хөгжлийн бодлогын баримт бичгээ боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 буюу Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах нийтлэг журмын 12 дугаар бүлгийн 52.1, 52.2, 52.3, 52.4-т заасны дагуу ерөнхий мэдээлэл, зорилго зорилт, хэрэгжүүлэх үе шат, үр нөлөө, шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн тусгасан байхад Баянтал сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө батлуулсан боловч түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах нийтлэг журмын дээрх заалтуудыг зөрчсөн байна.

Аймаг хөгжүүлэх хэтийн зорилт болон дэд хөтөлбөрүүдэд нөлөөлийн урьдчилсан үнэлгээ хийгээгүй байна. Энэ нь Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 24 дүгээр зүйлд “Нөлөөлийн урьдчилсан үнэлгээг төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна” гэснийг зөрчсөн байна.

Аймаг, сумд нь үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ хууль журамд заасны дагуу боловсруулсан боловч олон нийтийн хэлэлцүүлэг хийгээгүй бөгөөд тус аймгийн Хөгжлийн цогц бодлого нь 2010 онд боловсруулагдсан байна.

Иймд аймаг хөгжүүлэх хэтийн зорилт болон дэд хөтөлбөрүүдэд нөлөөлийн урьдчилсан үнэлгээ хийж, олон нийтээр хэлэлцүүлж байх ба сумдад хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулж, батлуулж, мөрдөж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.4 Зарим сум үндсэн чиглэлээ боловсруулж батлуулаагүй байж, төсөв авч зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх хөтөлбөр тус бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хамт боловсруулсан байх бөгөөд аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг журмын 8-р хавсралт дахь хүснэгтийн дагуу, дэд хөтөлбөрүүдийн арга хэмжээг журмын 6-р хавсралтын дагуу, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг дээрх журмын 7-р хавсралтын дагуу зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, санхүүжилт, эх үүсвэр, хэрэгжүүлэх байгууллага зэргийг тусгаж боловсруулсан байна.

Аймаг, сумдууд Хөгжлийн бодлогын баримт бичгээ боловсруулж зорилго, зорилт хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг бүрэн тусгасан бөгөөд харин Шивээговь сум 2017 оны үндсэн чиглэлээ батлаагүй атлаа 2,012.6 сая төгрөгийн төсөв батлуулан зарцуулсан байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Шивээговь сумын ИТХ-д үндсэн чиглэлээ боловсруулж, өргөн мэдүүлсэн Засаг даргад төсөв баталж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.5 Сумдын Засаг дарга нар Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг ИТХ-д өргөн мэдүүлэхдээ хуулийн хугацаа хоцроосон байна.

Аймаг, сумдын Засаг дарга нар 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, шат шатны ИТХ-д хүргүүлсэн байна.

Аймаг, сумдын Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг хүргүүлсэн байдлыг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг өргөн барьсан				Баталсан байгууллагын нэр
№	Нэр	Огноо	Албан бичгийн дугаар	
1	“Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөл	2016.10.03	A/1110	Аймгийн ИТХ
2	Дэд хөтөлбөрүүдийн жагсаалт /10 хөтөлбөр/	2016.11.21	A/1262	Аймгийн ИТХ
3	Баянтал сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөл	2016.12.14	532	Баянтал сумын ИТХ
4	Сүмбэр сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөл	2016.12.06	A/866	Сүмбэр сумын ИТХ

Хүснэгтээс харахад: аймгийн Засаг дарга хуулийн хугацаанд Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслөө өргөн мэдүүлж, сумдууд хугацаа хоцроосон байна Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10-р сарын 05-ны дотор ИТХ-д өргөн мэдүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Иймд сумдын засаг дарга нарт үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ хуулийн хугацаанд өргөн мэдүүлж байх зөвлөмж өгөхөр шийдвэрлэв.

1.6 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах, чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

Тухайн жилийн Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах саналуудыг сумдууд ЗДТГ болон харьяа байгууллагуудаас маягтын дагуу авч нэгтгэн сумын ИТХ-аар хэлэлцээд, аймгийн Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлдэг ба аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэс агентлагууд болон сумдаас ирсэн саналуудыг нэгтгэн боловсруулсан байна. Тухайлбал:

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс бүр, хариуцсан салбар бүрийн саналыг нэгтгэн оруулсан байна.

Сумдын бодлогын баримт бичигт тусгах саналыг сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд аймгийн үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн, өөрсдийн ажил үүргийн чиглэлээр санал оруулж, ЗДТГ-ын дотоод ажилтан нэгтгэх замаар боловсруулсан байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үү?

Бүлэг 2

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

2.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлагнасан байна.

Аймаг, сумд Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1 дүгээр хавсралтаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг жил бүр 02 дугаар сарын 20-ны дотор ЗГХЭГ-т, сумд 02 дугаар сарын 01-ний дотор аймгийн Засаг даргад тус тус хүргүүлж байхаар заасан бөгөөд дээрх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр хүргүүлсэн байна. Тухайлбал:

Аймгийн Засаг даргын тамгын газрын харьяа хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ-ууд Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг ХШҮДАХ-т хуваарьт хугацаанд ирүүлэх ажил хэвшсэн бөгөөд Засгийн газрын 89 дүгээр тогтоолд заасан хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн биелэлтийг ЗГХЭГ-т 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдөр 01/682, 01/683 тоот албан бичиг, аймгийн Засаг даргын үйл

ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн ИТХ-д 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр А/769, А/770 тоот албан бичиг, жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын даргын 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/1265 тоот албан бичгээр тус тус аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газраас Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг харьяа хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ-аас ХШҮДАХ-т ирүүлж байх хуваарийг Засаг даргын 2017 оны А/264 дүгээр захирамжаар батлуулан ажилласан бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд тайланг холбогдох газарт хүргүүлсэн байна

Сумдууд Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр сумын ИТХ болон аймгийн ХШҮДАХ-т хуваарийн дагуу хүргүүлж ажилласан байна.

2.2 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулсан байна.

Аймаг, сумд Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2 дугаар хавсралтаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг жил тутам, хяналт шинжилгээ үнэлгээг 2 жил тутамд хийж, жил бүрийн 02 дугаар сарын 20-ны дотор танилцуулж байхаар заасан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн ИТХ-д танилцуулах ажил тогтмолжсон байна.

Тухайлбал: Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2017 оны 7 дугаар сард аймгийн Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 онд аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Бодлогын баримт бичгийн үнэлгээг хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2 дугаар хавсралтад заасан хүснэгийн дагуу зорилт тус бүрийн хэрэгжилтийн хувийг гаргаж дүгнэсэн байна.

Тус хяналт-шинжилгээ, үнэлгээгээр аймгийн Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 52.8, 2017 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт 52.9 хувьтай үнэлэгдсэн байна.

Мөн 2017 оны эхний хагас жилд сумдын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг шалгаж, зөвлөмж өгч ажилласан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 3 дугаар улиралд дахин шалгахад аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээс удаашралтай, тасарч болзошгүй зорилт, арга хэмжээг хяналтандаа авч эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө хийгдээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланд зорилт тус бүрээр үнэлгээ хийж, аймгийн ИТХ-д 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр 01/1265 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-аар аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 86.6 хувь, 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 88.3 хувьтай тус тус үнэлсэн байна.

Сумдууд дараа оны үндсэн чиглэлийн төслийг батлуулахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцын хамт сумын ИТХ-д хүргүүлж, хэлэлцүүлсэн байна.

Сумдын ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж “хангалттай” гэсэн үнэлгээ өгсөн байна.

Сумдын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг аймгийн ХШҮДАХ-ээс жилд нэг удаа шалгаж байх хуваарийг аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулан, төлөвлөгөөний дагуу ажилласан байна. Тухайлбал: 2017 оны 10 сард аймгийн ЗДТГ-ын баталсан удирдамжийн дагуу сумдын Засаг дарга нарын үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, нийт 29 зөвлөмж өгч ажилласан байна.

2.3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэнд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-т “бүх шатны захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна” гэсний дагуу аймгийн Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэж, тайлагнах, үнэлж дүгнэх, биелэлтэнд нь хяналт тавих ажлыг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ хариуцан ажиллаж байна.

Эдгээрийг гүйцэтгэх үүрэг бүхий хэлтэс болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал: аймгийн ХШҮДАХ-ээс аймгийн Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хуваарьт болон хуулийн хугацаанд тайлагнаж ирсэн бөгөөд хагас жил тутамд хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, тухай бүр заавар зөвлөмж өгч ажилласан байна.

Сумдад Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг сумын ЗДТГ-ын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нэгтгэж, хагас бүтэн жилээр аймгийн ХШҮДАХ-т хүргүүлсэн байна.

Бүлэг 3

Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

3.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх сурталчлах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22-р зүйлд заасны дагуу батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичгийг жил бүр аймгийн веб сайтад байршуулсан бөгөөд эмхэтгэл болгон аймгийн ЗДТГ-ын харьяа агентлаг, сум бүрт тараасан байна.

Мөн 2017 онд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаар “Монголын мэдээ” сонинд сард 4 нүүр мэдээлэл тавьж, 1000 ширхэгийг захиалж тараадаг ба “Малчин телевиз”-д видео таницуулга хийсэн бөгөөд орон нутгийн “Dardas”.mn, “Залуус телевиз”-ээр 14 хоногт Засаг даргын харьяа агентлаг бүр үйл ажиллагаагаа танилцуулж, хэлтэс, агентлагууд жил бүр нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, жил бүрийн 12 дугаар сард аймгийн Засаг дарга иргэдтэй уулзалт зохион байгуулах зэрэг ажлууд хийгдсэн байна.

Сумд Хөгжлийн бодлогын баримт бичиг болон хэрэгжилтийг сумын ЗДТГ-ын веб сайтад тавих буюу боршур болгон багийн өдөрлөгөөр тарааж, эмхэтгэл болгон сумын Засаг даргын харьяа байгууллагуудад тус тус тараасан байна.

3.2 Зарим сумын Засаг дарга хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг дарга нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасны дагуу аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрүүд, үндсэн чиглэлийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын 7 дугаар бүлгийн 7.6-т заасны дагуу хуулийн хугацаанд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу аймгийн ИТХ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэж ирсэн байна.

Сүмбэр, Баянтал сумын Засаг дарга нар Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасны дагуу аймгийн бодлогын баримт бичгээс өөрийн суманд хамрааралтай арга хэмжээг бодлогын баримт бичигт бүрэн тусгасан ба хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр аймгийн ХШҮДАХ-т тайлагнаж ажилласан байна.

Харин Шивээговь сумын Засаг дарга нь сумын Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж, сумын ИТХ-д өргөн бариагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Засаг дарга аймаг нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна”, 16 дугаар зүйлийн 16.2-т “Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал батална” гэснийг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 2,012.6 сая төгрөгийн зөрчил дутагдал илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг 1: Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөлийн урьдчилсан үнэлгээ хийгээгүй, олон нийтээр хэлэлцүүлээгүй бөгөөд зарим сумд үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлээ төлөвлөөгүй, эрх бүхий байгууллагад өргөн барьж батлуулаагүй боловч төсөв зарцуулсан, хөгжлийн бодлогын баримт бичгийг өргөн барих хуулийн хугацааг хоцроосон байна.

Бүлэг 2: Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан ба хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна.

Бүлэг 3: Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх сурталчлах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан боловч зарим сумын Засаг дарга хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга болон ХОХБТХ-ийн даргад:

1. Аймаг хөгжүүлэх хэтийн зорилт болон дэд хөтөлбөрүүдэд нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийж, олон нийтээр хэлэлцүүлж байх

2. Үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж, батлуулаагүй Шивээговь сумын Засаг даргад заавар зөвлөмж хүргүүлэх

Сумдын Засаг дарга нарт:

1. Үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ хуулийн хугацаанд ИТХ-д өргөн мэдүүлж байх

Шивээговь сумын ИТХ-ын даргад:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ баталсан тохиолдолд төсвөө хэлэлцэн баталж байх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
42017 Чоёр, Говьсүмбэр аймаг
Утас: 7054 3118, E-mail: GSAimag@yahoo.com

2012.12.12 № 6/1320
тантай _____ -нм № _____ -т

**АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай
хуулийн хэрэгжилтэд хийсэн Нийцлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.
Тайлангийн төсөлтэй холбогдох санал
байхгүй болно.

ДАРГА  Д.СОДНОМ



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Холбогдох байгууллагаас ирүүлсэн тайлангийн төсөлд өгсөн саналтай танилцаад тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.